



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/317

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн Засаг даргын удирдлагын зөвлөлийн 2025 оны 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 15 дугаар тогтоолын дагуу "Солонго дулааны станц" аж ахуйн тооцоо үйлдвэрийн газрын хөрөнгөд бүртгэлтэй цахилгааны хаалттай дэд өртөө, цахилгааны магистраль шугамыг "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанид шилжүүлэхэд 7250 метр шугамын гэмтлийг мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэн засварлаж, хүлээн авах эрхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т шилжүүлсүгэй.

2. Холбогдон гарах зардал болох 8,000,000 (найман сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж олгохыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компани (Б.Цэдэвсүрэн)-д тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

